

## ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2021.02.26

Даланзадгад

Өмнөговь аймгийн 2020 оны 01 дүгээр сарын мэдээ

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл

2021.02 САРЫН МЭДЭЭ

### **ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Засгийн газрын 2020 оны 216, 217, 218 дугаар тогтоолуудаар Стратеги төлөвлөгөө, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөх, тайлагнах, үнэлэх журмууд тус тус батлагдсан. Мөн эдгээр журмуудтай уялдан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар дээрх төлөвлөлтийн маягтуудыг баталсан байгаа. Иймд дээрх журам, маягтын дагуу аймгийн төрийн байгууллага, албан хаагчид 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөж хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлага бий болж байна. Журмыг хэрэгжүүлэх, байгууллагын болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс, албан хаагчдад арга зүйн заавар, зөвлөмж өгөх ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан болно. Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг төсөвт байгууллагын 50 гаруй албан хаагч, аймгийн ЗДТГ-ын 20, 15 сумын ЗДТГ-ын дарга нарыг тус тус хамруулан холбогдох сургалтыг зохион байгуулна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, БНХАУ-д экспортлох нүүрний хэмжээ багассантай холбоотойгоор Сангийн дэд сайд С.Мөнгөнчимэгээр ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 02 сарын 15-ны өдрөөс 19-ний өдрүүдэд нүүрсний экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Гашуунсухайт хилийн боомт, Цагаанхад суурьшлын бүс орчимд ажиллалаа. Уг ажлын хэсэгт аймгийн Засаг дарга Р.Сэддоржоор ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг аймаг, орон нутгийн зүгээс хамтран ажиллаж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, ажлын төлөвлөгөө тайлан гаргах зэргээр хамтран ажиллалаа.

### **УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2021.01.25-02.22-ыг хүртэлх хугацаанд нийт 7 захирамжийн төсөл бэлдэж албажуулсан, цаг үеийн холбогдолтой 19 албан бичиг төлөвлөн гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн албан байгууллага, ААНБ-аас ирсэн 14 албан бичгийг шийдвэрлэж, холбогдох газарт хариу өгч хаасан байна.

## 1. Сургалт, Хэлэлцүүлэг, арга хэмжээ

- 2021 оны 02 сарын 01-ны өдөр Ханбогд сумын Хайрхан багийн “Цагаан хад” суурьшлын бүсийг ЦДАШ-аар холбох ажлын 2018 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотын Ганцмод боомт дахь 110 кВ-ын дэд станцаас шийдвэрлэхээр “Цахилгаан Эрчим Хүч Групптэй” ХХК хамтран цахим уулзалт хийж доорх асуудлын хүрээнд харилцан зөвшилцсөн. Үүнд:
  - БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотын дарга болон “Цахилгаан Эрчим Хүч Групп” ХХК-аас БНХАУ талын 35 кВ-ын ЦДАШ-ын төгсгөлийн тулгуурын J6 цэгийг өөрчилсөн талаар мэдэгдэж, J9 байршилын солбилцолыг танилцуулсан. Тулгуурын байршил өөрчлөгдсөнтэй холбоотой 2 улсын хилийн дунд баригдах шугамын урт 800 метр болж өөрчлөгдөж шинээр 2 тулгуур баригдахаар болсон. Уг тулгуурыг 2 улсын гүйцэтгэгч компани хариуцан нэг маягийн зургаар гүйцэтгэхээр харилцан тохиролцов.
  - Баяннуур хотын “Цахилгаан Эрчим Хүч Групп” ХХК-аас 2 улсын хилийн зурваст баригдах тулгуурын Хятад улсын эцсийн тулгуур хүртэлх ЦДАШ-ыг Монгол Улсын зүгээс шугамыг холбох ажлыг хариуцахаар тохиолцов.
  - Хятадын талаас 37 тулгуураас 24 тулгуурыг хийж гүйцэтгэсэн. Үлдсэн 13 тулгуурыг 2021 оны 6 сард хийж дуусгаад цахилгаан эрчим хүчээр хангана.
- 2021 оны 02 сарын 05-ны өдөр Монголын ОУИТБС-ын 2020 оны үйл ажиллагааны биелэлт, 2021 оны ажлын төлөвлөгөөг танилцуулах цахим уулзалтад хамрагдсан.
- 2021 оны 02 сарын 05-ны өдөр “Оюу толгой Уурхайн цогцолборын Гүний уурхайн хүдэр зөөвөрлөх шугамын Нэгдүгээр үе шатны ба техникийн комиссын хурал”-д цахимаар хамрагдсан.

### **ГАЗРЫН БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

1. Худалдааны төв зах байгуулах газрыг тодорхой болгож ажлын хэсгийн бүрэлдэхүүнд танилцуулав.
2. Даланзадгад сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар боловсруулж ГЗБГЗЗГ-с санал авахаар бичгээр хүргүүлэв.
3. Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний зургийн даалгаврыг эцэслэн боловсруулж ХААА-нд хүргүүлэв.
4. Нанзад хорооллын цахилгааны шугамын зургийн даалгаврыг эцэслэн боловсруулж ХААА-нд хүргүүлэв.

### **АВТО ТЭЭВРИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-д 1 дүгээр сарын захирамжийг гарган СТСХ-т хүргүүлсэн. Мөн Зөнгийн түшээ ХХК-ийн нөхөн олговрыг тус зардлаас шийдвэрлэн, захирамжийг СТСХ-т хүргүүлсэн.

### **БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Барилгын тухай хууль, холбогдох журмын дагуу улсын комисс ажиллуулах хүсэлтийг хүлээн авч 2 аж ахуйн нэгж байгууллага, иргэний хүсэлтийн дагуу улсын комисс ажиллах захирамжийг гарган ГХБХБГ-т хүргүүлэв.

1. Авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах, авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмын төсөл
2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 5 ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулан батлуулж, ОНӨГ-т хүргүүлэхээс гадна зураг, төсөл хийгдсэн 3 ажлын баримт бичиг буюу нийт 8 ажлын худалдан авах ажиллагааг зарлах ажлын бэлтгэж ажлыг хангаж ажиллалаа
3. Цэвэр, бохир усны төлөвлөлт, техникийн нөхцөл авах, ажлын даалгавар боловсруулан ажлыг хамтран гүйцэтгэж, судалгааны үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулав.
4. Ханбогд сумын нутаг дэвсгэр Ханбогд-Оюутолгой чиглэлийн 35,1 км хатуу хучилттай авто замыг орон нутгийн өмчид шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж холбогдох акт, дүгнэлтийг Оюутолгой ХХК-д хүргүүлэн шаардлагатай тоон мэдээг авах, хавсралт баримт бичгийг авахаар хүлээж байна
5. "COVID-19" цар тахлын хүнд үед аймгийн хэмжээнд Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд эхлэх болон он дамжин баригдах барилга, байгууламж, их засвар, өргөтгөлийн ажлуудын судалгаа, мэдээллийг нэгтгэн аймгийн Онцгой комисст зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай албан бичгийг хүргүүлэв.

#### **НИЙГМИЙН САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР:**

#### **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР:**

1. Коронавирусын (Ковид-19) халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шинжилгээ оношилгооны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн вируслогийн лабораторийн хэсгийг засварлах, тохижуулах засварлах ажлын гүйцэтгэл 80%-тай хэрэгжиж байна. 2021 оны 02 дугаар 27-ны өдөр лабораторийг байнгын ашиглалтад хүлээн төлөвлөн ажиллаж байна.
2. Шинэ коронавирусын (COVID-19) халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хангах зорилгоор Коронавирусын (COVID-19) халдвар илрүүлэхэд шаардлагатай 3500 ширхэг урвалж оношлуурыг хуваарилан эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.
3. Эрүүл шүд” дэд хөтөлбөрийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж эхэлсэн.
4. Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдал хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Коронавирусын болзошгүй эрсдэлтэй

холбоотойгоор 2021 оны 2 дугаар сарын байдлаар 494 иргэнийг гэрээр тусгаарлан ажиллаж, 7452 иргэнийг түргэвчилсэн тестээр шинжилгээнд хамруулж, 4490 иргэнийг PCR шинжилгээнд тус тус хамруулан ажилласан. Тандалт шинжилгээг нийт хүн амын дунд тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

## **ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**

1. Сар шинийн баяраар Өмнөговь аймагт амьдарч байгаа 90-ээс дээш насны 107 ахмадад хүндэтгэл үзүүлж Засаг даргын гарын бэлгийг гардуулсан.
2. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг баталж хамтын ажиллагааны гэрээнд аймгийн Засаг дарга гарын үсэг зурж баталгаажуулсан.
3. НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран ажиллах ажлын хэсэг байгуулагдсан.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөрт ИНБ-ууд оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийж салбар зөвлөлд зөвлөмж, дүгнэлтийг гардуулж өгсөн.
5. Гэр нь шатсан 2 өрхөд 4 болон 5 ханатай иж бүрэн Монгол гэрийн дэмжлэг үзүүлэн хүлээлгэн өгсөн.
6. Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн ажлыг эрчимжүүлж, салбар дундын хамтын ажиллагааг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын албан даалгаврыг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулан 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг хүлээн авсан.

## **БОЛОВСРОЛЫН САЛБАР**

1.Хүүхдэд Монгол ёс заншлаа дээдэлсэн, эх оронч,эрх чөлөөт сэтгэлгээтэй, үндэсний бахархлыг төлөвшүүлэх "Говийн ирээдүй-Хүүхэд" хөтөлбөрийг аймгийн ИТХТ-ийн 2021 оны 28 дугаар тогтоолоор батлууллаа.

2.2020 оны шилдэг сургууль, цэцэрлэг, багшийг шалгаруулж, шагнаж урамшууллаа. Оны шилдэг сургуулиар Баян-Овоо сумын сургууль, шилдэг цэцэрлэгээр Даланзадгад сумын 1 дүгээр цэцэрлэг, шилдэг багшаар Даланзадгад сумын 7 дугаар сургуулийн багш Б.Амгаланбаатар, 1 дүгээр цэцэрлэгийн багш Б.Цэцэгээ нар шалгарч, сургууль, цэцэрлэгийг 2.0 сая төгрөгөөр, багшийг 1.0 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулав.

3.2021 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах Сэврэй сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

## **ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:**

1. 32 лавлагаа, 185 хуулбар олгосон.
2. Шинээр тоо бүртгэлд 15 байгууллагын 387 хадгаламжийн нэгжийг бүртгэлд оруулсан.
3. 2020 онд нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан барилга байгууламжийн 402 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийв.

4. Архивын баримтад улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журмын дагуу хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивт хадгалагдаж байгаа баримтын мэдээг программд шивж баталгаажуулсан.

#### **САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

1. Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 1-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа.
2. Нийт 44 төсөвт байгууллагуудын 2021 оны 1 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан.
3. Төсвийн орлогын 1-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулан хүлээн авлаа.
4. Орон нутгийн байгууллагуудын 1 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
5. Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 2-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
6. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
7. Орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын баталгаажсан ажлын санхүүжилтийг олгож байна.
8. Аймгийн төрийн сангийн харъяа 44 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа.
9. Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрийбаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа.
10. Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.
11. 2020 оны жилийн эцсийн тайлан хүлээж авахтай холбогдуулан харъяа төсөвт байгууллагуудын дансны залруулах бичилтийг байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн төрийн сангийн фрийбаланси программд журналийн бичилт хийж ажилласан.
12. 2020 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн авахтай холбогдуулан орон нутгийн төсвийн байгууллагын батлагдсан төсвийг төсвийн мэргэжилтэн байгууллага тус бүрийн тайлантай нэг бүрчлэн тулган баталгаажуулж ажиллаж байна, төсвийн гүйцэтгэлийг дотоод хяналтын мэргэжилтэн байгууллага тус бүрийн тайлантай тулган баталгаажуулж байна, мөн тулган баталгаажуулах явцад зөрүү гарсан тохиолдолд тухай бүр залруулж ажиллаж байна.

13. 2020 оны сангуудын тайланг гаргаж аудитаар оруулхаар ажиллаж байна. Сумдын төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчит газруудын 2020 оны жилийн эцсийн тайланг хянан хүлээн авч байна.

14. Төрийн сан 2021 оны 03 сарын 01-ний өдрөөс Эрхийн бүртгэлийн системийг төлбөр тооцоондоо нэвтрүүлэхтэй холбогдуулан бэлтгэл ажил, дансны судалгаа, төрийн сан дахь төсвийн байгууллагын мэдээллүүдийг цахимд аүртгэх ажлууд хийгдэж байна.

15. ААНБ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг цахимаар хүлээн авч баталгаажуулалт хийж байна.

## **БАЯН-ОВОО**

**Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:**

“А” захирамж – 7, “А” тушаал – 2 тус тус гарсан байна.

**Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:**

Өмнөговь аймгийн Засаг дарга аймгийн цаг үеийн байдлаар иргэдтэй уулзалт хийж мэдээлэл өгсөн.

**Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:**

Баян-Овоо сумын 2020 онд амжилт бүтээлээрээ сумын ард иргэдээ хошуучилсан “11 хүнд сумын ТЭРГҮҮН шагналыг олгохоор сумын ИТХ-н тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн шийдвэрлэлээ. Сумынхаа хөдөлмөрчдийг болон малчдаа хошуучилсан 20 иргэд сумын тэргүүний албан хаагчид шагналыг Засаг дарга тамгын газраас олголоо. 2020 ондоо мал аж ахуйдаа өндөр амжилтыг гарган тогтмол ажиллаж байгаа 3 малчинд “сумын АВАРГА малчин” цол үнэмлэх шагналыг олголоо. Орон нутгийн төсөв: - Төлөвлөгөө-11000,0 үүнээс орсон орлого-5889,2 мян/төг буюу 53,5% гүйцэтгэлтэй.

## **БУЛГАН**

**Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр**

Энэ сард сумын ИТХ-аас 2 тогтоол, 3 асуудал хэлэлцсэн. Засаг даргаас А захирамж 13, ЗДТГазрын даргын А тушаал 5, Б тушаал 1 тус тус гарсан байна.

**Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ**

Сумын Хорио цээрийн дэглэм тогтоосны дагуу 2021.01.12-оос 2021.02.01-нийг хүртэл угтах үйлчилгээний жижүүрийн хуваарийг гарган ажиллаж байна. Эрүүл мэндийн төвийн Эмчийн үзлэгт 85 хүнийг хамруулсан. Хүүхдийн А аминдэмийн дархлаажуулалтад 110 хүүхдийг хамруулаад байна. Нийт 5 жирэмсэн эхийг хянаж байна.

**Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ**

Өмнөговь аймгийн Булган сумын нийт малчин өрхийн 80 гаруй хувь нь Цогт-Цэций, Хүрмэн, Баян-Овоо, Ханбогд, Номгон, Манлай-н нутгаар Отор нүүдэл хийж байгаа бөгөөд эхний ээлжид Цогт-Цэций суманд суугаа малчдад 1000 боодол өвс, Номгон суманд байгаа малчин өрхүүдэд 1000 боодол өвс 10 тонн тэжээл /Хивэг/ тус тус отроор байгаа хэсэгт ойртуулан хөнгөлөлттэй үнээр тараан малчдад тусламж үзүүллээ. Дараагийн ээлжид бусад суманд байгаа малчин өрхүүдэд тараах бэлтгэл ажлыг төлөвлөөд байна. Булган сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Улаан нуурын Хулсан-д оторлож яваа сумын 10 гаруй өрхөөр малчдын өвөлжилт, сумын өвөлжилтийн бэлтгэл ажил, цаг үеийн асуудлаар ярилцаж ард иргэдтэйгээ уулзалт хийлээ.

### **ГУРВАНТЭС**

**Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.**

Шивээхүрэн хилийн боомтоор нүүрс тээвэрлэлт явуулж эхэлсэнтэй холбогдуулан нүүрсний 4 уурхай, нүүрс тээврийн 37 ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Шивээхүрэн хилийн боомт болон Морин загийн постонд 2 байгууллагын албан хаагчид 13 ажиллаж байна. Өдөртөө 300, 350 нүүрс тээврийн авто машин хилээр тээвэрлэлт хийж байна. Сумын Засаг дарга 7 хоног бүрийн 3 өдөр Шивээхүрэн хилийн боомт Морин загийн постонд ажиллаж байна.

**Гурав: Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ:**

Сумын шуурхай жижүүрийг 24 цагаар гарган ажиллаж мэдээг 12, 20 цагт өгч байна. 2021 оны 02 сарын 09 Аймгийн орлогч дарга Н. Энхбатаар ахлуулсан ажлын хэсэг 2020 онд ажил хөдөлмөрөөрөө салбар салбартаа тэргүүлэн ажилласан иргэдэд шагналыг гардуулсан. МАК нь – 52 төрлийн ажлын байр зарлаж нийт 39 иргэн анкет бөглөсөнөөс 29 иргэн ярилцлаганд орсон. 2021 оны 02 сарын 12ны өглөөний 06:00 цагаас 2021 оны 02 сарын 15 өглөөний 06:00 цаг хүртэл Сумаас УБ чиглэл, Сумаас Өвөрхангай чиглэл болон Сумаас хөдөө чиглэлийн 9 постонд төрийн байгууллагын бүх албан хаагчид 24 цагаар гарч ажилласан

### **ДАЛАНЗАДГАД**

**Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.**

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Эрүүл иргэн-Хөгжлийн тулгуур”, “Чадварлаг багш-Хөгжсөн хүүхэд”, “Дэвшилтэт хотын оюунлаг залуучууд”, “Дэвшилтийг өрх бүрт”, “Даланзадгадад үйлдвэрлэв”, “Оюуны үр” 6 хөтөлбөрийг хэлэлцэн баталлаа. Засаг даргын А захирамж-21, Б захирамж-1, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал-6, Б тушаал-5, 2021

оны 02 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 50 албан бичиг хүлээн авсан. Засаг дарга болон Тамгын газраас 49 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Ирсэн санал, өргөдөл гомдол 10, шийдвэрлэж хаасан 6, Хугацаандаа яваа 4 санал өргөдөл байна.

### **Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал**

Даланзадгад сумын шуурхай штабаас өргөтгөсөн хурлыг зохион байгуулж дараах 3 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэлээ.

2021.01.28-нд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь Эрүүл мэндийн яам, “Эрүүл хот хөтөлбөр чадавхижуулах төв” ТББ, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран “Эрүүл хот ба өнөөгийн тулгамдсан асуудал, эрүүл зан үйл” сэдэвт цахим сургалтад сумын Засаг дарга, Эрүүл мэнд, спорт хариуцсан бодлогын мэргэжилтэн хамрагдсан.

### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

Монгол улсын Засгийн газраас өвөлжилт хүндэрсэн 5 аймгийн малчин өрхөд Дэлхийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төслийн шугамаар 300.000 төгрөгтэй тэнцэх хэмжээний тэжээлийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Тус дэмжлэгт 308 малчин өрх хамрагдсан. Даланзадгад сумын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар хуралдааны шийдвэрээр улсын нөөц, аймгийн нөөцөөс сумдад хуваарилсан нөөцийн өвсний үнийг тэглэн 626 малчин, мал бүхий өрхөд тус бүр 3 боодол өвсийг үнэгүй олгохоор шийдвэрлэж малчдад өвс олгох ажлыг зохион байгуулан ажиллалаа. Даланзадгад сумын 2021 оны төсвийн орлогын төлөвлөгөө 270599.7 мян.төгрөг гүйцэтгэл 188468.2 мян.төгрөг болж 69.6 хувь биелсэн, өөрийн орлогын төлөвлөгөө 500.0 мян.төгрөг, гүйцэтгэл 549.4 мян.төгрөг 109.9 хувьтай байна.

### **Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ**

ЕБС-ийн 12 дугаар ангийн сурагчдын давтлага зохион байгуулахтай холбогдуулан 12 дугаар ангийн багш нарыг ковидын шинжилгээнд хамруулах ажлыг 2 сарын 15-18-ны өдрүүдэд сургуулийн эмч, ӨЭМТөвтэй хамтран зохион байгуулсан. Сумын “Дархлаажуулалтын түр цэг”-ийг Спорт цогцолборын биеийн тамирын заал, Биеийн тамир, спортын төрөлжсөн сургалттай 7 дугаар сургуулийн харьяа хуучнаар Спорт заал, Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн урлаг заал, Баруунсайхан 1 дүгээр багийн төвийн хурлын зааланд байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Сар шинийн баярын өдрүүдэд сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хяналтын 14 постод 16 байгууллагын 226 төрийн албан хаагч ажиллаа. Бүх нийтийн их цэвэрлэгээг 02-р сарын 5, 6-ны өдрүүдэд зохион



байгуулж 02-р сарын 07-нд нийтийн эзэмшлийн гудамж, талбай ариутгал халдваргүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

#### **Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд**

Даланзадгад сумын 4-р багийн иргэн нь гэр нь шатсан өргөдөл, хүсэлт өгсний дагуу сумын Засаг дарга сар шинийн босгон дээр өргөө цагаан гэрийг шийдвэрлэж өглөө.

### **СЭВРЭЙ**

**Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.**

Сумын Засаг даргын А, Б захирамж нийт 9, Тамгын газрын даргын А тушаал 5 боловсруулан гарсан. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2 удаа хуралдаж 4 тогтоол шийдвэрлэн гаргасан.

#### **Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,**

2 дугаар сарын 18-ны өдөр Сумын ЗДТГ-ын дарга, Хууль эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар хамтран байгууллагын дарга эрхлэгч нар болон Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн нарт гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт зохион байгууллаа. Хамтарсан баг гишүүдийг чадавхижуулах дотоод сургалтыг зохион явуулж 8 гишүүнийг хамруулсан. Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүдийн онлайн уулзалт, сургалтад сумын хүүхдийн төлөө зөвлөлийн 5 гишүүнийг хамрагдсан.

**Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

Сайншанд Хоолт, Бүйлсэн багууд, сумын төвийн жирэмсэн эх болон нярай, өндөр настан ХБИ-ийг эргэх, отрын айл өрхөөр явсан. Явуулаар Саагийн болон товлолын даржлаажуулалт 32 хүүхдэд хийсэн.

Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 141 иргэн даатгалд хамрагдаж 11625,8 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалд 22 иргэн даатгалд хамрагдаж 890,4 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн. Тэтгэврийн даатгалын сангаас өндөр нас тахир дутуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг ХААН банкаар 266 иргэнд 96866,9 мянган төгрөг, Төрийн банкаар 32 иргэнд 11581,2 төгрөгийн тэтгэврийг олгосон.

**Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан Шинэлэг ажил, гарсан үр дүн:**

Цас тахал бүх нийт бэлэн байдал зарлагдсан үед сумын Цагдаагийн хэсэг автомашингүй, Эрүүл мэндийн төвийн авто машин хуучирч муудсан дуудлагад явахад хүндрэлтэй. Өнгөрсөн зун намар хур бороо багатай гандуу байсантай холбоотой бог малын хоргодол нэмэгдэж байна. Халаалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа 300 тонн буюу 27 хоногийн нүүрсний нөөцтэй.

## МАНДАЛ-ОВОО

### **Нэг .Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр**

Сумын ИТХ-н болон Тэргүүлэгчдийн тогтоол 7. /Сонгуулийн хэсэг байгуулах тухай/, Сумын Засаг даргын захирамж 6 /Мотоциклийн хөдөлгөөнийг түр хязгаарлах тухай/

### **Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт**

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурлыг 2 удаа, цахим хурал 1 удаа, байгууллагын дарга эрхлэгч нарын хурлыг 2 удаа, Онцгой комиссын хурлыг 2 удаа тус тус зохион байгуулав. Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд:

Өвс, тэжээлийн нөөцийг хөнгөлөлттэй үнээр олгох тухай, ISO 9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дотоод аудиторын сургалтад хамрагдах тухай, Цэргийн тоо бүртгэлийн тайлан гаргах тухай, Коронавирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээний хүрээнд Шуурхай штаб, эргүүл хяналтын постын ажлыг сайжруулах тухай, Мэдээ тайлангуудыг хугацаанд нь хүргүүлэх тухай, Зэрэг дэв шинээр авах болон ахиулах албан хаагчдын материал хүргүүлэх тухай

### **Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ**

-Өвс, тэжээлийн нөөцийг хөнгөлөлттэй үнээр олгох сумын Засаг даргын шийдвэр гарч хэрэгжиж байна. ISO 9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дотоод аудиторын сургалтад 6 албан хаагч хамрагдаж, амжилттай төгсөв. Цэргийн тоо бүртгэлийн тайланг гаргаж хугацаанд нь Цэргийн штабт тушаав. Тус сум нь 2020 оны Батлан хамгаалахын ажлаар Тэргүүн байр эзлэв. Коронавирусийн халдвараас сэргийлэх арга хэмжээний хүрээнд Шуурхай штаб, эргүүл хяналтын постын ажлыг сайжруулах тухай зөвлөмж чиглэл өгч, өдөр тутам аймгийн шуурхай штабт илтгэх хуудсаар мэдээ хүргүүлж байна. Зэрэг дэв шинээр авах 1, ахиулах 1 албан хаагчийн материалыг ТАСЗ-д хүргүүлэв. Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулж 112 иргэн хамрагдаж, 8 тн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулав. Улаан загалмайн тусламжийг 30 өрхөд хүргэв. 1 өрхөд 400000 төгрөгний тусламж олгогдов. Аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээллийг Баасан гараг бүр аймгийн Шуурхай штабт хүргүүлж байна. ТАХ-н Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, тайлагнах, үнэлэх нь сэдвээр дотоодын сургалт зохион байгуулж, 16 албан хаагч хамрагдав. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хүсэлтэй 2 иргэний материалыг хүргүүлж гэрээг байгуулав.

### **Дөрөв: Багт хийгдсэн ажлууд:**

Сумын хэмжээнд өвс тэжээлийн нөөц бэлтгэх, малчдад хямралтай үнээр хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Малчин өрхүүдэд улсаас үнэ төлбөргүй олгож байгаа 240 кг тэжээлийг 347 өрхөд тараах ажлыг зохион байгуулж, хэрэгжилт 88,2 хувьтай байна. "Малчдаа дэмжье" аяныг сумын МЗХ-ны

санаачлагаар эхлүүлэн 1 сарын 18-аас 3 сарын 18-н хүртэл хоёр сарын хугацаанд үргэлжлүүлэхээр хамтран ажиллаж байна. Малын сэг зэм устгах ажлыг Мандал багт зохион байгуулж байна.

\_oOo\_